



**ХААБ**  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ

## ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 4/07

Улаанбаатар хот

### Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 тоот тушаалын хавсралтын 7 дугаар зүйл, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн дүрмийн 14.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2016 онд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөг үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг Албадын захирлуудад үүрэг болгосугай.
3. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны захирал Д.Батжаргалд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ж.ЭРДЭНЭБАТ

000011



**"ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК-ИЙН 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
<i>Нэг. Хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх</i>				
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ 1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх, бүртгэл хөтлөх	Жилдээ	Захиргааны алба, ЭБАТ /эрх бүхий албан тушаалтан/
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	2.2. Боловсруулж байгаа дүрэм, журам, шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулж, итгэмжлэгдсэн этгээдүүд болон гишүүн оролцогчидтой санал солилцох	Тухай бүр	Захиргааны алба
3.		3.1. Тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин	Жилдээ	Захиргааны алба
		3.2. Хагас жилийн санхүүгийн тайлан	8 дугаар сарын 15-ны дотор	Захиргааны алба
		3.3. Жилийн эцсийн санхүүгийн тайлан	4 дүгээр сарын 25-ны дотор	Захиргааны алба
		3.4. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	4 дүгээр сарын 25-ны дотор	Захиргааны алба
		3.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	7 дугаар сарын 1-ний дотор	Захиргааны алба
		3.6. Зардлын хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	улирал бүр	Захиргааны алба

